

ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуульд эдийн засгийг хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, төсөв, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх төрийн чиг үүргийг тодорхойлсон байдаг.

Улсын Их Хурлын 1995 оны 87 дугаар тогтоолоор “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг баталж, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, орчин үеийн технологи, худалдаа, удирдлагын арга барилыг нэвтрүүлэх, ажлын байр болон валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор чөлөөт бүс хөгжүүлэх бодлогын үндсийг тавьсан.

Чөлөөт бүсийн тухай хууль 2015 онд батлагдсанаас хойш Монгол Улсын хөгжлийн бодлого, эдийн засгийн бүтэц, хөрөнгө оруулалтын орчин, олон улсын худалдаа болон технологийн чиг хандлагад томоохон өөрчлөлт гарсан. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт чөлөөт болон тусгай бүс, боомт, логистик, аж үйлдвэр, өндөр технологи, инноваци, аялал жуулчлал, санхүүгийн үйлчилгээ, мэдээллийн технологид тулгуурласан төрөлжсөн хөгжлийн төвүүдийг бий болгох зорилтыг тусгасан.

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ болон практик нөхцөл байдлын судалгаагаар одоогийн эрх зүйн зохицуулалт нь дээрх бодлогын зорилтыг бүрэн хангахад хүрэлцэхгүй, эдийн засгийн тусгай бүсийг олон улсын хөгжлийн чиг хандлага болон Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан төрөлжүүлэх шаардлагатай гэж үзсэн.

Дээрх хэрэгцээ, шаардлагад үндэслэн Чөлөөт бүсийн тухай хуулийг “Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль” нэрээр шинэчлэн найруулж, эдийн засгийн тусгай бүсийг Монгол Улсын бүсчилсэн хөгжил, хөрөнгө оруулалт, экспорт, үйлдвэрлэл, технологи, инноваци, логистикийн бодлоготой уялдсан нэгдсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд хөгжүүлэхээр хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөлд дараах зарчмын шинэлэг зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэг. Эдийн засгийн тусгай бүсийн нэр томьёо, ангиллыг системчилсэн.

Эдийн засгийн тусгай бүсийг ерөнхий ойлголт болгон тодорхойлж, бүсийг үйл ажиллагааны чиглэл, зориулалт, байршлын онцлогоос нь хамааран худалдаа, экспортын зориулалт, аж үйлдвэр, технологи-инноваци, логистик-тээвэр болон аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Хоёр. Бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах шалгуурыг нарийвчилсан.

Хуулийн төсөлд гадаад улстай хил залгаа нутаг дэвсгэрт тусгай бүс байгуулах асуудлыг Улсын Их Хурлын шийдвэрээр, бусад нутаг дэвсгэрт тусгай бүс байгуулах тохиолдолд Засгийн газар байгуулахаар хуульчилсан.

Бүс байгуулах шийдвэрийг техник, эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо, байгаль орчны үнэлгээ, дэд бүтцийн бэлэн байдал болон тухайн бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан гаргах мөн зорилгоо хангахгүй, эдийн засгийн үр ашиггүй болсон бүсийг татан буулгах эрх зүйн үндсийг тодорхой болгосон.

Гурав.Хөнгөлөлт, чөлөөлөлтийн харилцааг нарийвчлан зохицуулсан.

Хөрөнгө оруулагч бүрд ижил нөхцөлөөр хөнгөлөлт үзүүлэх аргаас татгалзаж, хөрөнгө оруулалтын хэмжээ, бий болгосон ажлын байр, экспортын гүйцэтгэл, технологийн түвшин, салбарын онцлог болон тухайн бүсийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан ялгамжтай тусгай дэглэм хэрэглэх эрх зүйн үндсийг бий болгосон.

Дөрөв.Газрын харилцааны тусгай зохицуулалтыг боловсронгуй болгосон.

Хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах зорилгоор урт хугацааны газар ашиглалт, тусгай бүсийн газрын гэрчилгээ, цахим кадастр, мэдээллийн ил тод тогтолцоог бүрдүүлэх болон газрын үнэлгээнд зах зээлийн аргачлал ашиглах нөхцөлийг тусгасан.

Тав.Нэг цонхны үйлчилгээг бодитой хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Зөвшөөрөл, бүртгэл, татвар, гааль, газар, барилга, хөдөлмөр зэрэг төрийн үйлчилгээг бүсийн захиргаагаар дамжуулан цахим хэлбэрээр шуурхай үзүүлэх, холбогдох төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үүргийг тодорхой болгосон.

Зургаа.Эдийн засгийн тусгай бүсийн мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор тусгасан.

Бүсийн бүртгэл, зөвшөөрөл, газар, гааль, татвар болон бусад мэдээллийг төрийн мэдээллийн сангуудтай уялдуулах, мэдээллийн аюулгүй байдал, нэвтрэх эрх, хариуцлагын тогтолцоог хуульчилсан.

Долоо.Удирдлагын тогтолцоог шинэчилсэн.

Бүсийн удирдлагад шийдвэр гаргах олон шат дамжлагатай байсныг хялбарчилж, чиг үүрэг давхардсан, бүсийн захиргааны эрх хэмжээ болон санхүүгийн бие даасан байдал хангалтгүй байсныг зохицуулсан.

Найм. Хөрөнгө оруулагчийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулсан.

Оюуны өмч, худалдааны нууцыг хамгаалах, маргааныг шүүх, арбитр, эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх, хуульд заасан нөхцөлд төрийн өмчит компанийн оролцоотой маргаанд олон улсын арбитрыг сонгох болон арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгосон.

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засгийн тусгай бүсийг худалдаа, үйлдвэрлэл, экспорт, технологи, инноваци, логистик зэрэг чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх эрх зүйн суурь бүрдэж, хөрөнгө оруулалт татах, экспортын үйлдвэрлэл болон импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай болгох нөхцөл бүрдэх ач холбогдолтой.

Хуулийн төсөлтэй уялдуулан татвар, гааль, хөрөнгө оруулалт, газар, зөвшөөрөл, улсын бүртгэл, хөдөлмөр эрхлэлт, мэдээллийн хамгаалалт, оюуны өмч, арбитр, эвлэрүүлэн зуучлал болон шүүхийн ажиллагаатай холбоотой бусад хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг хамтад нь боловсруулсан.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль

- Хуулийн төслийг Үндсэн хуульд заасан хууль дээдлэх, өмчийн эрхийг хамгаалах, татвар, төлбөр, хураамжийг хуулиар тогтоох, төрийн байгууллагын эрх хэмжээг хуулиар тодорхойлох, иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зарчимд нийцүүлэн боловсруулсан.

Эдийн засгийн тусгай бүсийн зохицуулалт нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эрх мэдлийн хуваарилалт, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын хамгаалалт, өмчийн эрх, шүүхэд хандах эрх, хувийн мэдээлэл хамгаалах эрхийг хөндөхгүй. Тусгай бүсийг төрийн өмчит компанийн хэлбэрээр байгуулж, олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх зохицуулалт нэвтрүүлэхдээ шүүх эрх мэдлийн бие даасан байдал, шүүхэд хандах иргэний үндсэн эрхийг хөндөхгүйгээр, гэрээний талуудын сайн дурын зөвшөөрлөөр маргаан шийдвэрлэх нэг хэлбэр болгон зохицуулна.

- Нэр томьёоны нэгдмэл байдлыг хангах зорилгоор “чөлөөт бүс”, “эдийн засгийн чөлөөт бүс”, “эдийн засгийн тусгай бүс”, “тусгай бүс”, “олон улсын санхүүгийн төв” зэрэг ойролцоо нэршлийг холбогдох хууль тогтоомжид нэг мөр болгоно. Энэ хүрээнд Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль, Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн нэр томьёо, зохицуулалтыг шинэ хуультай нийцүүлнэ. Мөн одоо байгаа чөлөөт бүсүүдийг шинэ ангилалд хамруулах шилжилтийн зохицуулалтыг тусгаж, шаардлагатай тохиолдолд тухайн бүсийг байгуулсан шийдвэрт өөрчлөлт оруулсан.

- Хуулийн төсөлтэй холбогдуулан Засгийн газрын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Патентийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Арбитрын тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

- Мэдээллийн нэгдсэн сан болон төрийн бусад мэдээллийн нэгдсэн сантай холбох хоорондын суурь зохицуулалтыг хуульд тусгаснаар нэг цонхны үйлчилгээг бодитоор шуурхай, чанартай хэрэгжих үндэс бүрдэхээр байна. Энэ хүрээнд мэдээллийн нэгдсэн сангийн эрх зүйн орчинг иж бүрэн бүрдүүлэхэд хувийн мэдээллийн хамгаалалтыг зохицуулсан хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон хүний хөгжил, нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтийг оруулах шаардлагатай. Хууль хоорондын нийцлийн хувьд Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар нь чөлөөт бүсийн нэгдсэн санд тодорхой мэдээллийг тодорхой хугацааны дотор нийлүүлэх буюу хуваалцах үүргийг тусгайлан хуульд тусгана.

- - - оОо - - -